

## АГУУЛГА

### УДИРТГАЛ

#### ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

1. ХҮН АМ
2. ӨРХ
3. ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ
4. ЭРҮҮЛ МЭНД
5. БОЛОВСРОЛ
6. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ
7. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
8. АЮУЛГҮЙ БАЙДАЛ
9. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛЭЭС



## БҮЛЭГ 1. ХҮН АМ

*Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино<sup>1</sup>.*

---

<sup>1</sup> Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого

## 1.1. Нийслэлийн хүн амын тоо

2020 оны ээлжит тооллогоор Улаанбаатар хотод Монгол Улсын харьяат 1 539 810 хүн ам тоологдсон. Үүнээс 1 448 642 нь нийслэлийн нутаг дэвсгэрт оршин суугаа Монгол Улсын харьяат иргэн, 91 168 нь гадаадад 6 түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэн байна.

Нийслэлийн хүн ам 2010-2020 оны хоорондох хугацаанд 24.2 хувиар өсөж, жилийн дундаж өсөлт 2.7 хувь болж, 2000-2010 оны жилийн дундаж өсөлтөөс ойролцоогоор 2 дахин буураад байна. Жилийн дундаж өсөлт буурсан гол шалтгаан нь хотын хүн амын өсөлтийн дийлэнхийг бүрдүүлэгч шилжилт хөдөлгөөн буурсан явдал юм. УБ хотын дүүргүүдийн хүн амын өсөлт харилцан адилгүй байна. Тухайлбал, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хувьд хүн ам 0.2-1.4 хувиар буюу хамгийн бага өсөлттэй байхад Хан-Уул дүүргийн хүн амын өсөлт 7.8 хувь байгаа нь Улаанбаатар хотын дунджаас 2.6 дахин өндөр өсөлт. Энэ нь сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт орон сууцны хорооллууд ихээр баригдсантай холбоотой.

УБ хотын хүн амын насны бүтцэд 2010 онтой харьцуулахад зарим өөрчлөлт гарсан нь нийт хүн амд эзлэх 0-9 насныхны хувийн жин өсөж, 2011 оноос төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой. Харин 15-29 насны бүлэг дэх хүн амын дүнд эзлэх хувь бага байгаа нь 1990-ээд оны эхэн үеэс 2006 он хүртэлх хугацаанд төрөлтийн түвшин бага байснаар тайлбарлагдана.

## 1.2 Хүн амын хүйсийн харьцаа

Хүйсийн харьцаа 2010 онд 92.9, 2020 онд 92.8 болсон нь нийт хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байгааг илэрхийлж байгаа бөгөөд хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам мэдэгдэхүйцээр буурч байгаа нь эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалт харьцангуй ялгаатай (2019 оны байдлаар дундаж наслалт эрэгтэй- 67.06, эмэгтэй 75.11) байгаатай холбоотой. Дэлхийн улс орнуудын хувьд ч энэ зүй тогтол адил байдаг боловч тухайн орны хүн амын насжилттай холбоотойгоор хүйсийн харьцаа буурч эхлэх нас харилцан адилгүй байна. Хүйсийн харьцааг төрсөн хүүхдийн хувьд авч үздэг бөгөөд УБ хотод сүүлийн таван жилд 100 эмэгтэй хүүхэд тутам 104- 108 эрэгтэй хүүхэд мэндэлсэн байна.

Дүүргүүдээр авч үзвэл 2020 онд хүйсийн харьцаа Баянгол дүүрэгт хамгийн бага буюу 89.7, Багахангай дүүрэгт хамгийн өндөр буюу 101.9 байна. Энэхүү үзүүлэлтийг 2010 онтой харьцуулахад Багануур, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хүн амын хүйсийн харьцаа бага зэрэг нэмэгдэж, харин Багахангай, Налайх, Хан-Уул, дүүргийн хүн амын хүйсийн харьцаа өмнөх тооллогын үеийнхээс бага зэрэг буурчээ. Сүүлийн 30 жилд хүн амын голч нас 20.6-аас 28.7 болж 8 жилээр хойшилсон нь төрөлтийн бууралтаас гадна дундаж наслалт нэмэгдэж байгаатай холбоотой.

### 1.3 Хүн ам зүйн ачаалал

Хүн ам зүйн ачаалал 2020 онд 58.3 болж 1989 оноос 9.3 пунктээр буурч, 2010 оноос 19.1 пунктээр өсжээ. Дээрх суваргад хөдөлмөрийн насны хүн ам буюу 25- 34 насны бүлгийн хүн ам харьцангуй их харагдаж байна. Хүн амын дунд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь нэмэгдэж байгааг харж болно. Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “хүн ам зүйн цонх” гэдэг. Хөдөлмөрийн насны хүн амын тоо их байгаа буюу хүн ам зүйн цонх үеийг ашиглан урт хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, ялангуяа ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарснаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд эергээр нөлөөлөх юм.

### 1.4 Хүн амын суурьшил, нягтрал

Монгол Улсын хүн амын 45.9 хувь нь буюу 2 хүн тутмын нэг нь Улаанбаатар хотод оршин сууж байна. Хотын хүн амын нягтрал 2000 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 162 хүн, 2010 онд 245 хүн, 2020 онд 312 болж өссөн нь орон нутгаас шилжин ирэлт их байгааг харуулж байна. Нийслэлийн нийт хүн амд дүүргүүдийн эзлэх хувь 2010 онтой харьцуулахад алслагдсан гурван дүүрэг болох Багануур, Багахангай, Налайх дүүргийн нийт хүн амд эзлэх хувь өөрчлөгдөөгүй 10 жилийн хугацаанд хадгалагдан үлджээ. Харин төвийн дүүргүүдийн хувьд өөрчлөлт гарсан байна. Тухайлбал, Хан-Уул дүүрэг бусад дүүргүүдийг бодвол хамгийн их буюу 3.2 пунктээр өссөн. Байршлын ялгаатай байдлаас шалтгаалан хүн амын нягтрал дүүргүүдэд харилцан адилгүй байна. Хүн амын нягтрал хамгийн ихтэй дүүрэг Баянгол (9 254), харин хамгийн их хүн амтай нь Баянзүрх дүүрэг байна.

### 1.5 Шилжиж ирсэн хүн ам

УБ хотын суурин хүн амын 947 117 (64.6%) хүн төрснөөсөө хойш нийслэлд амьдарч байгаа бол 519 008 (35.4%) хүн шилжин ирж суурьшсан, үүний дотор 511 678 (34.9%) хүн өөр аймаг хотоос, 7 330 (0.5%) нь гадаадаас шилжин иржээ. Шилжин ирж суурьшсан хүн амын 55.0 хувь нь эмэгтэй, 45.0 хувь нь эрэгтэйчүүд байв.

Нийслэл хотод сүүлийн 5 жилд 72.9 мянган хүн шилжин ирсэн нь 2010 оноос 2.5 дахин, сүүлийн нэг жилд шилжин ирэгчдийн тоо 55.3 мянгад хүрч, өмнөх тооллогоос 6 мянган хүнээр тус тус буурчээ. 2010 онд нийслэл хотод амьдарч байгаа хоёр хүний нэг нь шилжин ирэгч байсан бол 2020 онд гурван хүний нэг нь шилжин ирэгч болсон байна.

Сүүлийн 5 жилд УБ хот руу шилжин ирсэн урсгалыг бүс нутгаар харахад нийт шилжин ирэгчдийн 30.8 хувь нь төвийн бүсээс, 29.2 хувь нь Хангайн бүсээс иржээ. Улаанбаатар хотод 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын товоос өмнөх нэг жилд нийт 69.2 мянган хүн шилжих хөдөлгөөнд оролцсон нь 2010 оны тооллогын үеэс 32.0 мянган хүнээр буурчээ.

## 1.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо

*Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хэлнэ<sup>2</sup>*

Төрөлхийн хөгжлийн бэрхшээл гэж удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг ойлгоно. Олдмол хөгжлийн бэрхшээл гэж ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг ойлгоно.

Нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 36.7 мянган хүн байгаагийн 20.2 мянга (55.1%) нь эрэгтэй, 16.5 мянга (44.9%) нь эмэгтэйчүүд байна. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 18.3 мянган хүн байгаа нь өмнөх тооллогоос 72.8 хувиар өссөн, харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй 18.4 мянга хүн байгаа нь өмнөх тооллогоос 31.4 хувиар буурсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 52.8 хувь нь төрөлхийн, 57.3 хувь нь олдмол, эмэгтэйчүүдийн 47.2 хувь нь төрөлхийн, 42.7 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна.

**Хүснэгт 1.1** Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, төрлөөр, 2010-2020

№	Бэрхшээлийн төрөл	2010	2020
1	Харааны	5265	4188
2	Хэл ярианы	1042	1109
3	Сонсголын	2420	3137
4	Хөдөлгөөний	10855	7652
5	Сэтгэцийн	6981	7316
6	Хавсарсан		2360
7	Бусад	7831	

Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, "Нийслэлийн нэгдсэн дүн"

Хөгжлийн бэрхшээлтэй хүний 11.4 хувь буюу 4.2 мянган хүн харааны, 3.0 хувь буюу 1.1 мян хүн ярианы, 8.6 хувь буюу 3.1 мянган хүн сонсголын, 20.9 хувь буюу 7.7 мянган хүн хөдөлгөөний, 19.9 хувь буюу 7.3 мянган хүн сэтгэцийн, 6.4 хувь буюу 2.4 мянган хүн хавсарсан, 29.8 хувь буюу 10.9 мянган хүн бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байна.


## 1.7 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, насны бүлгээр

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нас, хүйсийн суваргаас харахад 15-19 насны бүлгээс дээш насны 55-59 насны бүлэг хүртэл нас ахих тусам хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо

<sup>2</sup> УСХ, Нийгмийн зарим үзүүлэлт

өсч байснаа 60-аас дээш насны бүлэгт буурсан байна. 54-69 насны хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүн амын тоо эмэгтэйчүүдээс илүү байгаа нь ажиглагдаж байна.

**Зураг 1.1** Хөгжлийн бэрхшээлтэй хүний нас хүйсийн суварга, 2010, 2020



Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, “Нийслэлийн нэгдсэн дүн”

Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас баралтын голлох шалтгааны нэг нь осол болж байгаатай холбоотой байгаа ба бага, залуу насныхны дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн тохиолдол өндөр байснаа нас ахихад олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэх хандлага байна.

### 1.8 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, дүүргээр

Нийслэлийн дүүргийн хүн амд эзлэх хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийг авч үзэхэд Баянгол 2.3, Хан-Уул 2.4, Сүхбаатар 2.4, Баянзүрх 2.2, Сонгинохайрхан 3.3, Багануур 3.8, Багахангай 4.1, Налайх 4.2, Чингэлтэй 3.0 хувийг эзэлж байна.

**Хүснэгт 1.2.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, дүүргээр, эзлэх хувиар, 2010, 2020

№	Дүүргийн нэр	2010	2020
1	Баянгол	2.8	2.3
2	Баянзүрх	3.2	2.2
3	Багануур	5.3	3.8
4	Багахангай	4.3	4.1
5	Налайх	4.7	4.2
6	Сүхбаатар	3.4	2.4
7	Сонгинохайрхан	2.5	3.3
8	Хан-уул	3.4	2.4
9	Чингэлтэй	3.4	3.0


Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, “Нийслэлийн нэгдсэн дүн”

### 1.9 Гадаадад оршин сууж байгаа хүн ам

Гадаадад 183 хоногоос дээш хугацаагаар оршин сууж байгаа болон 183 хоногоос доош хугацаагаар сууж байгаа ч цаашид 183 хоногоос дээш хугацаагаар оршин суух нь тодорхой болсон хүн амыг хамруулна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор гадаадад оршин суугаа 91168 иргэн тоологдож 2010 оноос 6.3 хувиар өсчээ. Гадаадад тоологдсон иргэдийн хоёр хүний нэг нь буюу 53.1 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, дөрвөн хүн тутмын нэг нь Европ тивд байгаа бөгөөд эдгээр хүмүүсийн 35.8 хувь нь суралцахаар, 11.5 хувь нь суурьшихаар, 10 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр, 1.1 хувь нь албан томиллоор, 18.5 хувь нь ажиллахаар, 13.1 хувь нь гэр бүлийн, 10.0 хувь нь бусад шалтгаанаар гадаадад оршин сууж байна.

**Зураг 1.2.** Гадаад оршин суугаа нийслэлийн иргэдийн зорилго, хувиар, 2020




Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, “Нийслэлийн нэгдсэн дүн”

### 1.10 Өрх толгойлсон эцэг/эхийн тоо

2019 онд нийслэлийн хэмжээнд өрх толгойлсон хүн **18931** байгаа нь 2016 оноос 10.8 хувь, өнгөрсөн ббүн 4.3 хувиар буурсан бөгөөд нийт өрх толгойлсон хүний 79.7 хувь нь эмэгтэйчүүд, 20.3 хувь нь эрэгтэйчүүд байна.

**Зураг 1.3.** Өрх толгойлсон эцэг/эхийн тоо, 2016-2019




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан: [www.1212.mn](http://www.1212.mn)

### 1.11 Арван найм хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эхийн тоо

Нийслэлд 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эхийн тоо 2019 онд **9874** болж, өмнөх оноос 531, 2016 оноос 1805 өрхөөр буурсан байна. Сүүлийн 4 жилийн динамикаас харахад 18 хүртэлх насны 4 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эхийн тоо буурч байна.

**Хүснэгт 1.4.** 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эхийн тоо, 2016-2019




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан: [www.1212.mn](http://www.1212.mn)

## 1.12 Хагас ба бүтэн өнчин хүүхдийн тоо

Бүтэн өнчин хүүхэд гэж эцэг эх нь тогтоогдоогүй, эсвэл эцэг эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эцэг, эх нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ. Хагас өнчин хүүхэд гэж эцэг эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, мөн эцэг эх хоёрын аль нэг нь тогтоогдоогүй, нас барсан, сураггүй алга болсон эрх зүйн чадамжгүй болсон 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.

2019 оны байдлаар хагас өнчин 11670 хүүхэд байгаа бөгөөд энэ нь 2016 оноос 1.3 хувиар, өссөн, өнгөрсөн оноос 0.6 хувиар буурсан. Бүтэн өнчин 1424 хүүхэд байгаа нь 2016 оноос 1.2 хувь, өнгөрсөн оноос 0.1 хувиар тус тус буурсан байна.

**Зураг 1.5.** Хагас, бүтэн өнчин хүүхдийн тоо, 2016-2019



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан: [www.1212.mn](http://www.1212.mn)

## 1.13 Үрчлэгдсэн хүүхдийн тоо


Үрчлэн авагч нь хүүхэд үрчлэн авсан тухайгаа иргэний гэр бүлийн асуудал эрхэлсэн тухайн шатны албанд бүртгүүлж, гэрчилгээ авсан тохиолдлыг ойлгоно. Үрчлүүлсэн хүүхдийн тоог тухайн жилд дотоодын болон гадаадын иргэнд үрчлэгдсэн нийт хүүхдийн тоогоор тодорхойлно<sup>3</sup>.

<sup>3</sup> Хүүхэд хамгааллын статистик үзүүлэлт тооцох аргачлал



**2019** онд 667 хүүхэд үрчлэгдсэн нь 2016 оноос 0.5, өнгөрсөн оноос 0.1 хувиар өссөн байна.

*Зураг 1.6. Үрчлэгдсэн хүүхдийн тоо, 2016-2019*



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан: [www.1212.mn](http://www.1212.mn)



## БҮЛЭГ 2. ӨРХ

*“Алсын хараа-2050” Урт хугацааны хөгжлийн бодлогын гол цөм нь “Монгол хүн” байж хөгжлийн бодлогын зорилго бүр нь Монгол хүний сайн, сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэж байгаа юм. Дэлхий нийтийн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын суурь эхлэлтийн цэг нь ногоон хөгжил байх бөгөөд байгаль орчны нөөц бололцоо, газар зүйн байршлын давуу тал дээрээ үндэслэн эдийн засаг, дэд бүтэц, бүс нутгаа хөгжүүлэх болно. Эдийн засгийн хөгжлийн үр дүнд бий болгосон баялгийг хүндээ хүргэж нийгмийн хөгжлийг бий болгоно. Ухамсартай, боловсролтой иргэд ирээдүйд байгаль орчноо зохистой ашигладаг болно<sup>4</sup>.*

---


<sup>4</sup> “Алсын хараа-2050” Урт хугацааны хөгжлийн бодлого

## 2.1 Өрх, өрхөд хамааралгүй хүн амын тоо

Хүн амыг өмнөх тооллогын нэгэн адил өрхөд, өрх үүсгээгүй нэгжид тоологдсон гэж 2 ангилсан. Өрх үүсгээгүй нэгж гэж нийтээрээ буюу хэсэг бүлгээрээ амьдарч байгаа, хоорондоо ураг, төрөл, хамаатан садны ямар нэг холбоогүй хүмүүсийг хэлнэ. Өрх үүсгээгүй нэгжийн хүмүүс ихэвчлэн цэрэг, хоригдол, оюутан сурагчид болон ажиллагчдын нийтийн байр, эмнэлэг, сувилал, зочид буудлын нэг өрөөнд хамт амьдарч байгаа болон орон сууцны нэг өрөө буюу бүхэлд нь хөлслөн сууж байгаа мөн байшингийн дээвэр хонгил, орц, дулааны шугам сүлжээний сувагт хамт амьдардаг, ураг төрөл, хамаатан садны холбоогүй хүмүүс юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр 411.4 мянган өрхөд суурин хүн амын 97.3 хувь буюу 1 426 085 хүн, өрх үүсгээгүй нэгжид 2.7 хувь буюу 40 040 хүн байна. Өрхөд тоологдсон хүний тоо өмнөх тооллогын үеийнхээс 311.2 мянган (27.9%) хүнээр, өрх үүсгээгүй нэгжид тоологдсон хүний тоо 0.6 мянган (1.7%) хүнээр өссөн байна. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр Монгол Улсад амьдарч байгаа нийт 897.4 мянган өрхийн 411.4 мянга (45.8%) нь нийслэл хотод амьдарч байна. Энэ нь өмнөх тооллогын дүнгээс 109.2 мянган (36.1%) өрхөөр өсчээ.

Зураг 2.1. Өрх, өрхөд хамааралгүй хүн амын тоо, 2020



Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, "Нийслэлийн нэгдсэн дүн"

## 2.2 Өрхийн тоо, хэлбэрээр

Өрхийн талаарх мэдээлэл нь тухайн орны ёс заншил, өрх гэр бүлийн өөрчлөлтийг судлахад ач холбогдолтойгоос гадна хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн бодлого төлөвлөлтийн үндсэн гол мэдээлэл болж өгдөг. Нийслэлийн нийт өрхийн 52.4 хувийг ам бүлээрээ байгаа өрх, 28.9 хувийг нийлмэл өрх, 14.6 хувийг ганц бие өрх, 4.1 хувийг холимог өрх эзэлж байна. 2010 оны тооллогын дүнгээс нийт өрхөд ганц бие өрх, холимог өрхийн эзлэх хувь 1.5- 5.1 пунктээр өссөн бол ам бүлээрээ байгаа өрх, нийлмэл өрхийн эзлэх хувь 1.4-5.2 пунктээр буурсан байна.

УБ хотод байрны олдоц, үнэ, иргэдийн боломж зэрэг олон хүчин зүйлээс үүдэн залуу гэр бүл эцэг, эхтэйгээ хамт амьдарч нийлмэл өрхийг үүсгэдэг байна. Энэ удаагийн тооллогоор нийт өрхөд нийлмэл өрхийн эзлэх хувь буурч байгаа нь нэлээд эерэг үзүүлэлт юм. Үүнийг төрөөс залуу гэр бүлийг дэмжиж урт хугацааны ипотекийн зээл олгож байгаа нь нийлмэл өрхийн хувь багасахад гол нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Энд анхаарал татаж байгаа зүйл бол ганц бие өрхийн тоо болон хувь нэмэгдэж байгаа явдал юм.

**Зураг 2.2. Нийслэлийн өрхийн тоо, хэлбэрээр, 2020**



Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, “Нийслэлийн нэгдсэн дүн”

### 2.3 Өрхийн тоо, дүүргээр

2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад Хан-Уул (78.0%), Баянзүрх (42.8%), Сонгинохайрхан (42.0%) дүүрэгт өрхийн тоо хамгийн их өсжээ. Энэ нь нэг талаар орон нутгаас шилжин ирсэн өрхүүд дийлэнхдээ Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт суурьшдаг, нөгөө талаар Хан-Уул дүүрэгт орон сууцжилт ихээр явагдаж байгаагаас үүдэн нийслэлийн бусад дүүргүүдээс шилжин ирж амьдарч байгаатай холбоотой. Энд онцлоход Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийн өрхийн өсөлт бусад дүүргүүд болон нийслэлийн дунджаас 16.6-31.8 пунктээр доогуур байна.

**Хүснэгт 2.1. Өрхийн тоо, эзлэх хувиар, дүүргээр, 2010, 2020**


Дүүрэг	2010		2020	
	өрхийн тоо	эзлэх хувь	өрхийн тоо	эзлэх хувь
<b>Нийслэл</b>	<b>302 242</b>	<b>100.0</b>	<b>411 420</b>	<b>100.0</b>
Багануур	6 430	2.1	8 133	2.0
Багахангай	952	0.3	1 131	0.3
Баянгол	47 507	15.7	62 976	15.3
Баянзүрх	73 376	24.3	104 764	25.5
Налайх	8 093	2.7	10 248	2.5
Сонгинохайрхан	65 866	21.8	93 521	22.7
Сүхбаатар	33 513	11.1	40 061	9.7
Хан-Уул	28 782	9.5	51 241	12.5
Чингэлтэй	37 723	12.5	39 345	9.5

Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, “Нийслэлийн нэгдсэн дүн”

### 2.4 Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн тоо

Нийслэлийн хэмжээнд 2020 байдлаар хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн тоо **4992** байгаа бөгөөд энэ нь нийт өрхийн 6.4 хувийг эзэлж байна.

**Зураг 2.3.** Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн тоо, дүүргээр



Эх үүсвэр: Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

## 2.5. Өрхийн тоо, амьдардаг сууцны төрлөөр

УБ хотод амьдарч байгаа 411420 мянган өрхийн 22.2 хувь нь уламжлалт сууц гэрт, 77.3 хувь нь байшинд, 0.5 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.

**Зураг 2.4.** Өрхийн тоо, амьдардаг сууцны төрлөөр, 2020



Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, “Нийслэлийн нэгдсэн дүн”


## 2.6 Гэрт амьдардаг өрхийн тоо

УБ хотод 91.2 мянган өрх гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеэс 4.2 хувиар буюу 3.7 мянган өрхөөр нэмэгджээ. Гэрт амьдардаг өрхийн 83.0 хувь нь 5 ханатай гэрт амьдарч байна. Эндээс монголчууд таван ханатай гэрт түгээмэл амьдардаг нь харагдаж байна. Гэрт амьдардаг 91.2 мянга өрхийн 96.6 хувь нь энгийн нүхэн жорлон хэрэглэдэг нь хамгийн өндөр хувьтай байна. Гэрт амьдардаг өрхийн 96.6 хувь нь хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар зөөвөрлөдөг, хатуу хог хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх 1.9 хувь, шатаадаг болон булдаг 86 өрх (0.1 хувь) байна. Нийслэлийн гэрт амьдардаг өрхийн 86.5 хувь нь зориулалтын цооногт бохир усаа асгадаг бол 13.5 хувь нь задгай асгадаг аж.

## 2.7 Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн эзлэх хувь

УБ хотын нийт өрхийн 99.5 хувь буюу 409179 өрх төвлөрсөн систем, 0.3 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж болон бага оврын цахилгаан үүсгүүрээр цахилгааны хэрэгцээгээ хангаж байна.

**Зураг 2.5. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн тоо, төрлөөр, 2020**




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан: [www.1212.mn](http://www.1212.mn)

## 2.8 Стандартын шаардлага хангасан усан хангамжийн системд холбогдсон өрхийн тоо, дүүргээр, 2020

Төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс ус түгээх шугамаар дамжуулан усаар найдвартай тасралтгүй хангагддаг болон стандартын шаардлага хангасан төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон худгаас ундны усаа авдаг өрхийн тоогоор илэрхийлэгдэнэ.

Нийслэлийн нийт өрхийн 47.3 хувь нь төвлөрсөн болон бие даасан системд холбогдсон байна.

**Зураг 2.6. Шаардлага хангасан усан хангамжийн системд холбогдсон өрхийн тоо, дүүргээр, 2020**




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан: [www.1212.mn](http://www.1212.mn)

## 2.9 Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон болон холбогдоогүй өрхийн тоо

2020 оны байдлаар нийслэлийн нийт өрхийн 50.0 хувь буюу **204073** өрх цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон байна.

**Зураг 2.7. Цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон болон холбогдоогүй өрхийн тоо, дүүргээр, 2020**




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан: [www.1212.mn](http://www.1212.mn)

## 2.10 Өрхийн сарын дундаж орлого

Нэг өрхийн сарын дундаж нийт орлого улсын дунджаар 2019 онд 1.3 сая төгрөг болж, өмнөх оныхоос 162.3 (13.7%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Хотод нэг өрхийн сарын дундаж нийт орлого 2019 онд 1.5 болсон байна.

**Зураг 2.8. Өрхийн сарын дундаж орлого, мян төгрөг, 2018-2019**




Эх үүсвэр: YCX, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, 2019

## 2.11 Өрхийн сарын дундаж орлого, төрлөөр

Өрхийн мөнгөн орлогыг төрлөөр нь бүсээр задлан харвал, цалин хөлсний орлого УБ хотод бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр 954.1 мянган төгрөг буюу мөнгөн орлогын 66.2 хувийг эзэлж байна.

**Зураг 2.9. Өрхийн сарын дундаж орлого, төрлөөр, бүсээр, 2019**




Эх үүсвэр: YCX, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, 2019

## 4.12 Өрхийн сарын дундаж нийт зарлага

2019 онд өрхийн сарын дундаж нийт зарлага УБ хотод 1.5 сая төгрөг болж, өмнөх оныхоос 148 (14.2%) төгрөгөөр нэмэгджээ.

**Зураг 2.10.** Өрхийн сарын дундаж зарлага, 2018-2019



Эх үүсвэр: ҮСХ, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, 2019





### **БҮЛЭГ 3. ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ**

*Монгол Улсын Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын эрхэм зорилго нь гэр бүлийн амьдралын түвшинг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар монгол хүний хөгжлийг дэмжихэд оршино.*

Гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих, гэр бүлийн хөгжил, үр хүүхдээ асран хамгаалахад эцэг, эхийн жигд оролцоог хангах, гэр бүлээрээ амьдрах орон сууцтай болохыг дэмжих, гэр бүлийн өмчийн харилцаанд гишүүн бүрийг эрх тэгш оролцуулах, хүн амын эмзэг бүлгийн нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг гэр бүлд төвлөрүүлэх, гэр бүлд зориулсан үйлчилгээний сүлжээг бий болгох, гэр бүлийн гишүүнийг хүчирхийлэх, эрхийг нь зөрчих явдлыг тууштай бууруулах, эрх зүй, зан үйлийн эерэг орчин бүрдүүлэх нь энэхүү бодлогын үндсэн зорилт болно.

### 3.1 Гэрлэлт, гэр бүл цуцлалтын тоо

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар манай оронд 18 нас хүрсэн хүн гэрлэх боловч гэрлэгчид хоёулаа эсхүл хэн нэг нь 18 нас хүрээгүй хүнийг иргэний хуульд заасны дагуу “иргэний эрх зүйн бүрэн чадамжтай (хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх 16-18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж тооцно.)” гэж зарласан тохиолдолд гэрлэлтийг хүчинтэйд тооцно.

Хүн амын төрөлт, өсөлтөд шууд нөлөөлдөг хүчин зүйл бол гэр бүлийн байдал юм. Гэрлэх нь үндэсний соёл, уламжлалтай нягт холбоотой явагддаг нийгмийн үзэгдэл тул түүний үндсэн төрх тооллого хоорондын жилүүдэд төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар өдөрт 12 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 55 хос гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Харин энэ үзүүлэлт нийслэлд харгалзан цуцлалт 7, гэрлэлт 29 байна. 1000 хүн амд ногдох *гэрлэлт* нийслэлд улсын хэмжээнээс 1.6 пунктээр (Улаанбаатар 11.4, улсын хэмжээнд 9.8 ), *гэр бүл цуцлалт* 0.8 пунктээр (Улаанбаатар 2.9, улсын хэмжээнд 2.1 ) тус тус өндөр байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын дотор гэр бүлтэй хүн амын эзлэх хувь 61.4 болж 2010 оныхоос 4.7 пунктээр өсжээ. Хүснэгтээс харахад ч 2000 оноос хойш гэр бүлтэй хүний тоо тогтмол нэмэгдэж байна. Өнгөрсөн 10 жилд арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын дотор гэр бүл цуцалсан хүний эзлэх хувь 1.0 пунктээр буюу 6.5 мянган хүнээр буурчээ. Харин бэлэвсэн хүний тоо 8.3 мянган хүнээр буюу 0.3 пунктээр өссөн аж.

*Хүснэгт 3.1. Хүн амын тоо, гэр бүлийн байдал, хүйс, хувиар, 2020*

Гэр бүлийн байдал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь	мян.хүн	эзлэх хувь
Нийт	<b>975.4</b>	<b>100.0</b>	<b>458.2</b>	<b>100</b>	<b>513.3</b>	<b>100</b>
Огт гэр бүл болоогүй	300.8	30.8	155.9	34.0	144.9	28.0
Гэр бүлтэй	598.8	61.4	285.9	62.4	313.0	60.5
Цуцалсан	26.0	2.7	8.8	1.9	17.2	3.3
Бэлэвсэн	49.8	5.1	7.6	1.7	42.2	8.2

*Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, “Нийслэлийн нэгдсэн дүн”*

### 3.2 Гэрлэлтийн байдал, насны бүлэг, хүйсээр

Тухайн насны бүлгийн хүн амд ногдох гэрлэлтийн байдлыг хүйсээр харахад 15- 24 насанд эрэгтэйчүүдийн огт гэр болоогүй хувь эмэгтэйчүүдийнхээс 4.9 пункт, 25-34 насанд эмэгтэйчүүдийнхээс 7.6 пунктээр тус тус илүүрхэж, улмаар нас ахих тусам аль аль хүйс нь ойролцоо түвшинд буурсан байна.

**Хүснэгт 3.2. Гэрлэлтийн байдал, насны бүлэг, хүйсээр, хувиар, 2020**

насны бүлэг	эрэгтэй					эмэгтэй				
	бүгд	гэр бүл болоогүй	гэр бүлтэй	цуцлалсан	бэлэвсэн	бүгд	гэр бүл болоогүй	гэр бүлтэй	цуцлалсан	бэлэвсэн
Дүн	100.0	34.0	62.4	1.9	1.7	100.0	28.0	60.5	3.3	8.2
15-24	100.0	94.1	5.9	0.0	0.0	100.0	89.2	10.7	0.1	0.0
25-34	100.0	40.7	58.6	0.6	0.1	100.0	33.1	65.2	1.4	0.3
35-44	100.0	14.2	83.3	2.1	0.4	100.0	12.3	81.8	4.0	1.9
45-54	100.0	8.6	85.6	4.4	1.4	100.0	7.0	78.0	7.2	7.8
55-64	100.0	4.2	86.4	4.6	4.8	100.0	3.8	67.5	6.4	22.3
65+	100.0	1.7	79.7	2.1	10.5	100.0	1.5	45.0	2.1	51.4

Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, "Нийслэлийн нэгдсэн дүн"

### 3.3 Гэрлэлтийн дундаж нас


Хүн ам зүйн судалгааны гол үзүүлэлтийн нэг бол анхны гэрлэлтийн дундаж нас юм. Энэ үзүүлэлтийг тодорхойлсноор тухайн улсын хүн амын гэр бүлийн ерөнхий төлөв байдлыг дүгнэх боломжтой болдог. Анхны гэрлэлтийн дундаж насыг тухайн насны хүн амд эзлэх огт гэр бүл болоогүй хүн амд үндэслэн тооцдог бөгөөд өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэйчүүд дунджаар анх хэдэн насандаа гэр бүл болж байгааг илэрхийлдэг.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 34.0 хувийг огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүд эзэлж байхад, эмэгтэйчүүд 28.0 хувийг буюу 6.0 пунктээр бага байна. Энэ зөрүү 2010 онд 4.7 пункт байсан бол энэ удаагийн тооллогоор 1.3 дахин нэмэгджээ.

### 3.4. Гэрлэлт, цуцлалтын тоо, дүүргээр

2019 онд нийслэлийн хэмжээнд **10721** хос гэрлэж, **2713** хос гэрлэлтээ цуцлуулсан байна.

**Зураг 3.1. Гэрлэлтээ батлуулсан гэр бүлийн тоо, дүүргээр, 2020**




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 3.5. Гэр бүл цуцлалт, насны бүлэг, хүйсээр

Гэрлэлтээ цуцлуулж байгаа 3 хос тутмын хоёр нь 10 ба түүнээс дээш жил хамт амьдарсныхаа эцэст гэр бүлээ цуцлуулсан бөгөөд хүний тоог хүйсээр ангилж үзэхэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс аль ч насны бүлэгт ойролцоогоор хоёр дахин их, ялангуяа

45-54 насанд хамгийн их зөрүүтэй байна. Эндээс дүгнэхэд эрэгтэйчүүдийн дахин гэрлэлт эмэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байдгийг харуулж байна

**Зураг 3.2.** Гэр бүлээ цуцалсан хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2020



Эх үүсвэр: ҮСХ, НЗДТГ, Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, "Нийслэлийн нэгдсэн дүн"



## БҮЛЭГ 4. ЭРҮҮЛ МЭНД

*Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын зорилго хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан монгол хүний дундаж наслалтыг уртасгахад оршино<sup>5</sup>.*


---

<sup>5</sup> ЗГ-ын 2017 оны 24 дүгээр тогтоолын хавсралт

#### 4.1 Төрөлтийн коэффициент

Нийслэлд 2019 оны 1000 хүн амд ногдох төрөлт (ТЕК) нь **23.9** байгаа бөгөөд өмнөх оноос 0.5-аар өссөн байна. Төрөлтийн ерөнхий коэффициент Хан-уул дүүрэгт хамгийн өндөр буюу 4.3 -аар илүү байна.

Зураг 4.1. Төрөлтийн коэффициент, дүүргээр, 2018-2019



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан: [www.1212.mn](http://www.1212.mn)

#### 4.2 Эх хүүхдийн эндэгдэл

Нийслэлд 2019 онд **41206** хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 503 (1.2%) хүүхдээр олон байна. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн эмнэлэгт шинээр мэндэлсэн 41206 хүүхдэд регистрийн дугаар олгожээ.

Хүснэгт 4.1. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, 2019

Үзүүлэлт	2017	2018	2019
Амаржсан эхийн тоо	38115	40373	<b>40823</b>
Амьд төрсөн хүүхдийн тоо	38404	40703	<b>41206</b>
Эхийн эндэгдэл	12	11	<b>10</b>
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн тоо	489	555	<b>530</b>
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насандаа эндсэн хүүхэдийн тоо	12,7	13,6	<b>12,9</b>

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн эмхэтгэл, 2019


Нялхсын эндэгдлийн 81 (15.3%) нь Баянзүрх, 91 (17.2%) нь Сонгинохайрхан, 39 (7.4%) нь Чингэлтэй, 38 (7.2%) нь Баянгол, 32 (6.0%) нь Хан-Уул, 38 (7.2%) нь Сүхбаатар, 13 (2.4%) нь Налайх, 6 (1.1%) нь Багануур, 192 (36.2%) нь бусад аймгийн харьяат байна.

#### 4.3 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох) нь амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог илэрхийлнэ.

2019 онд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл **14.9** байгаа нь 2016 оноос 3.3, өмнөх оноос 1.2 пунктээр буурсан. Улсын дүнгээс УБ 1.2 пунктээр доогуур байна.

Зураг 4.2. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, 2016-2019




Эх үүсвэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв

#### 4.4 Өсвөр насны охидын жирэмслэлтийн коэффициент

Өсвөр насандаа жирэмслэх, хүүхэд төрүүлэх нь охидын хувьд нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавартай. Нийгэм дэх байр сууриа тодорхойлж, ирээдүйн амьдралынхаа эхлэлийг тавих насандаа хүүхэд төрүүлэх нь тэдний сурч хөгжих боломжийг багасгаж, улмаар нийгмээс тусгаарлагдмал, ядуурал болон хүчирхийлэлд өртөх магадлалыг нэмэгдүүлдэг байна.

2019 онд өсвөр насны охидын жирэмслэлтийн коэффициент **40.7** байгаа нь 2016 оноос 2.5 пунктээр өссөн бөгөөд өнгөрсөн оноос 0.2 -оор тус тус буурсан байна. Өсвөр насны охидын жирэмслэлийн коэффициент улсын дүнгээс 8.5 пунктээр өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 4.3. Өсвөр насны охидын жирэмслэлтийн коэффициент (2016-2019)




Эх үүсвэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв

#### 4.5 Өсвөр насны төрсөн охидын эзлэх хувь

Өсвөр насны охидын төрөлтийн хувь нь тухайн жилийн нийт төрөлтийн дунд өсвөр насны охидын төрөлтийн эзлэх хувь хэмжээг илэрхийлнэ.

2019 оны байдлаар нийслэлийн өсвөр насны охидын төрөлтийн хувь улсын дүнгээс 0.2 хувь доогуур байгаа бөгөөд өнгөрсөн оноос 0.3 хувь буурчээ.

**Зураг 4.4. Өсвөр насны төрсөн охидын эзлэх хувь, 2016-2019**




Эх үүсвэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв

#### 4.6. Өсвөр насны охидын үр хөндөлтийн тусгай коэффициент

Өсвөр насны үр хөндөлтийн коэффициент нь тухайн жилийн өсвөр насны 1000 охидод ногдох үр хөндүүлсэн өсвөр насны охидын тоог илэрхийлнэ<sup>6</sup>.

**2019** онд өсвөр насны охидын үр хөндөлтийн коэффициент **12.2** байгаа нь улсын дүнгээс 5.0-аар өндөр байгаа ба өмнөх оноос мөн 0.8-оор буурсан. Өсвөр насны охидын үр хөндөлт нийслэлд хамгийн өндөр байна.

**Зураг 4.5. Өсвөр насны охидын үр хөндөлтийн коэффициент, 2016-2019**



Эх үүсвэр: Эрүүл мэндийн хөгжлийн төв

<sup>6</sup> Эрүүл мэндийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал





## БҮЛЭГ 5. БОЛОВСРОЛ

*“Боловсролын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж заасан. Энэхүү хуульд заасны дагуу манай улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрдэнэ.*

## 5.1 Боловсролын түвшин

Монгол Улсын хэмжээнд арав, түүнээс дээш насны хүн амын 95.1 хувь нь ямар нэгэн боловсролын түвшин эзэмшиж байгаа бол Улаанбаатар хотод энэ үзүүлэлт **95.9** хувь болж, өмнөх тооллогын үеэс 0.4 пунктээр буурсан байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 10, түүнээс дээш настай хүн амын дотор бага боловсролтой хүн 9.2 хувь, суурь боловсролтой хүн 9.4 хувь, бүрэн дунд боловсролтой хүн 32.7 хувь, техникийн болон мэргэжлийн дунд боловсролтой хүн 3.0 хувь, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн 5.3 хувь, дээд боловсролтой хүн 36.3 хувь байна. Арав, түүнээс дээш насны нийт хүн амд боловсролгүй хүн амын эзлэх хувь 2020 онд өмнөх тооллогоос эрэгтэйчүүд 0.5 пункт, эмэгтэйчүүдийн 0.3 пунктээр өсөв.

Зураг 5.1. Боловсролын түвшин, 10 түүнээс дээш насны хүн амын хувьд



Эх үүсвэр: Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, “Нийслэлийн нэгдсэн дүн”

## 5.2 Бичиг үсгийн мэдлэг

Монгол Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амын **98.7** хувь нь бичиг үсэг тайлагдсан бол нийслэлд энэ үзүүлэлт 99.5 хувьтай байгаа нь улсын дунджаас 0.8 пунктээр өндөр, өмнөх тооллогоос 0.1 пунктээр нэмэгджээ. Арван тав, түүнээс дээш насны хүн амын 0.5 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаа нь нийслэл хотынхон маань бүгд бичигтэн болсныг харуулж байна.


## 5.3 Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын жин

СӨБ-д албан ёсоор суралцах насандаа элссэн суралцагчдын тооны тухайн насны нийт хүүхдэд эзлэх хувиар хамран сургалтын цэвэр жинг тодорхойлно. Бохир жин нь тухайн шатанд сурч байгаа хүүхдийн тоог суралцвал зохих нийт хүүхдийн тоонд харьцуулсан илэрхийлэл болно.<sup>7</sup>

Нийслэлийн СӨБ-ын байгууллагад 2019/2020 оны хичээлийн жилд 2-5 насны нийт хүүхдийн **81.5** хувь нь цэцэрлэгт хамрагдсан нь 2016/2017 оны хичээлийн жилээс 9.5, өнгөрсөн жилээс 1.4 хувиар өссөн байна.

<sup>7</sup> Боловсролын статистикийн үзүүлэлтүүд тооцох аргачлал

Зураг 5.2. Хамран сургалтын жин, хувиар, 2016-2019 он



Эх үүсвэр: Боловсролын салбарын статистик мэдээллийн эмхэтгэл (VIII)

#### 5.4. СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нь 2-5 насны СӨБ-д хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоогоор илэрхийлнэ<sup>8</sup>

2019/2020 оны хичээлийн жилд нийслэлд 555 хүүхэд СӨБ-д хамрагдсан бөгөөд төрөлхийн 419, олдмол 136 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

Хүснэгт 5.1. СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, дүүргээр, 2019

дүүрэг	харааны	ярианы	сонс- голын	хөдөл- гөөний	сэтгэ- цийн	оюуны	аутизм	дауны х.шинж	хавсар- сан
Багануур				1				1	
Баянгол	18	24	1	16	2	4	13	7	56
Баянзүрх	5	9	3	95		5	14	6	24
Налайх	2	3		3					1
Багахангай									
Сонгино- хайрхан	4	2	4	11	4	1	7	3	49
Сүхбаатар	6	10	11	2	1		28	9	7
Хан-уул	3	2	4	5	3	1	32	3	4
Чингэлтэй	2	2	1	8			4	6	4
Төрийн	24	25	23	115	3	6	49	26	48
Төрийн бус	16	27	1	26	7	5	49	9	96
Нийт	40	52	24	141	10	11	98	35	144

Эх үүсвэр: Боловсролын салбарын статистик мэдээллийн эмхэтгэл (VIII)


#### 5.5 ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Энэ үзүүлэлт нь 6-17 насны хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдүүдээс ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог илэрхийлнэ.

2019/2020 оны хичээлийн жилд 257 ЕБС-д 2692 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна.

<sup>8</sup> Хүүхэд хамгааллын статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлал

**Зураг 5.3.** ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд, 2016-2019 он



Эх үүсвэр: Боловсролын салбарын статистик мэдээллийн эмхэтгэл (VIII)

### 5.5 ЕБС-ийн дотуур байранд амьдардаг хүүхдийн тоо

2019/2020 оны хичээлийн жилд нийслэлийн 16 ЕБС-ийн дотуур байранд 1502 хүүхэд амьдарч, үүнээс малчдын хүүхэд 351 байна.

**Зураг 5.4.** Сургуулийн дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо, ангиар, 2019 он



Эх үүсвэр: Боловсролын салбарын статистик мэдээллийн эмхэтгэл (VIII)




## БҮЛЭГ 6. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

*Нийгмийн хамгааллын стратегид нийгмийн хамгаалал гэдэг нь “үр өгөөжтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмзэг аюултай байдал болон орлогогүй болохоос сэргийлэх чадварыг бий болгосноор ядуурал, эмзэг байдлыг бууруулахад чиглэгдсэн багц бодлого, хөтөлбөр” гэжээ.*

## 6.1 Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн тоо

2019 оны байдлаар нийслэлд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай буюу 0-409,669 оноотой **74098** өрх байгаа бөгөөд эдгээр өрхийн 32.6 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 22.8 хувь нь Баянзүрх дүүрэгт, 14.6 хувь нь Чингэлтэй дүүрэгт тус тус байна.

**Зураг 6.1.** Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн тоо, дүүргээр, 2020




Эх үүсвэр: Нийслэлийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

## 6.2 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур өрхийн тоо

Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 3 дугаар зүйлд зааснаар хүн амын амьжиргааны доод түвшин гэж “...хүн амын хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг, хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээ”-г ойлгоно.

**Зураг 6.2.** Амьжиргааны доод түвшин, 2018-2020




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан: [www.1212.mn](http://www.1212.mn)

### 6.3 Хүнсний эрхийн бичигт хамрагдсан өрхийн тоо

Нийслэлд 2019 оны байдлаар нийгмийн халамжаас **38943** өрхөд хүнсний эрхийн бичиг олгосон бөгөөд **14545** хүүхэд, **42534** насанд хүрэгчид хамрагдсан байна.

Зураг 6.3. Хүнсний талонд хамрагдсан өрхийн тоо, дүүргээр, 2020



Эх үүсвэр: Нийслэлийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар





## БҮЛЭГ 7. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

*Хөдөлмөр эрхлэлт нь иргэн бүр ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, хувийн аж ахуй эрхлэх эрхийг хангахад чиглэх бөгөөд иргэдийн эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, орлогын түвшин, амьдралын чанараа дээшлүүлэх үндсэн баталгаа, улс орны хөгжлийн үндэс болно<sup>9</sup>.*

---

<sup>9</sup> Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого



## 7.1 Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэлийн хэмжээнд 2019 оны 12 дугаар сард 6712 болж, өмнөх оны мөн үеэс 1564 (18.9%) хүнээр, өмнөх сараас 747 (10.0%) хүнээр тус тус буурсан байна.

Бүртгэлтэй нийт ажилгүй иргэдийн 3610 (53.8%) нь эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй ажилгүй иргэдийн 2357 (35.1%) нь 25-34 насны залуучууд, 1613 (24.0%) нь 35-44 насныхан, 1223 (18.2%) нь 45-аас дээш насныхан, 1519 (22.6%) нь 15-24 насныхан байна

*Хүснэгт 7.1. Бүртгэлтэй ажилгүй иргэд, дүүргээр, хувиар, 2019*

№	Дүүргийн нэр	Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хувь	Хөгжлийн бэрхшээлтэй ажилгүй иргэдийн хувь
1	Баянзүрх	22.8	4.8
2	Чингэлтэй	11.3	14.5
3	Сонгинохайрхан	14.8	13.4
4	Баянгол	17.2	16.9
5	Сүхбаатар	13.6	18.1
6	Хан-Уул	9.9	10.8
7	Багануур	4.8	10.8
8	Налайх	2.4	4.8
9	Багахангай	3.2	5.0

*Эх үүсвэр: Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал" статистик эмхэтгэл, 2019*

Бүртгэлтэй нийт ажилгүй иргэдийн 1533 (22.8%) нь Баянзүрх, 992 (14.8%) нь Сонгинохайрхан, 1153 (17.2%) нь Баянгол, 914 (13.6%) нь Сүхбаатар, 761 (11.3%) нь Чингэлтэй, 664 (9.9%) нь Хан-Уул, 323 (4.8%) нь Багануур, 214 (3.2%) нь Багахангай, 158 (2.4%) нь Налайх дүүрэгт тус тус амьдарч байна. Нийслэлийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 83 (1.2%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд 37 (44.6%) нь эмэгтэйчүүд байна.

## 7.2 Ажилд зуучлан орсон иргэдийн тоо

Дүүргүүдийн хөдөлмөр эрхлэлтийн албанд 2019 оны 12 дугаар сард ажилгүй 3615 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 1733 иргэн ажилд зуучлагдан орж, 2629 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Өмнөх оны мөн үеэс шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 229 (6.8%) хүнээр, ажилд зуучлагдан орсон иргэд 300 (20.9%) хүнээр ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 386 (17.5%) хүнээр тус тус өссөн байна.

**Зураг 7.1. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, 2019**



Эх үүсвэр: Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистик эмхэтгэл, 2019

2019 оны 12 дугаар сард бүртгэлтэй ажилгүй иргэдээс хөдөлмөр эрхлэлтийн албадаар зуучлагдан ажилд орсон 1733 хүний 10 (0.6%) нь төрийн бус байгууллагад, 168 (9.7%) нь төсөвт байгууллагад, 1555 (89.7%) нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд орсон байна.

#### 7.4 Ажиллагчдын тоо, хүйс, бүсээр

УБ хотод 470998 ажиллагчид байгаагийн 250102 нь эрэгтэйчүүд, 220896 нь эмэгтэйчүүд байна. Ажиллагчдын 471.0 мянга (41.1%) нь Улаанбаатар хотод амьдарч байна.

**Хүснэгт 7.2. Ажиллагчид, байршил, бүс, хүйсээр**

Бүс	бүгд		хүйсээр			
	тоо	хувь	эрэгтэй		эмэгтэй	
			тоо	хувь	тоо	хувь
Улсын дүн	1 146 160	100.0	606 814	100.0	539 346	100.0
Баруун	147 618	12.9	76 893	12.7	70 725	13.1
Хангайн	239 417	20.9	125 973	20.8	113 444	21.0
Төвийн	201 345	17.5	107 024	17.6	94 321	17.5
Зүүн	86 782	7.5	46 822	7.7	39 960	7.4
<b>Улаанбаатар</b>	<b>470 998</b>	<b>41.1</b>	<b>250 102</b>	<b>41.2</b>	<b>220 896</b>	<b>41.0</b>

Эх үүсвэр:ҮСГ, Ажиллах хүчний судалгаа

Нийслэлд нийт ажиллагчдын 31.5 % нь төрийн байгууллага (төсөвт), төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагад 6.4.0% нь, ТӨААТҮГ-т 52.8 %, ОУБ-д 75.5 хувь нь ажиллаж байна.

#### 7.5 Хөдөлмөрийн дутуу ашиглалт

Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байгаа хүн ам буюу хөдөлмөрийн дутуу ашиглалт 2019 онд улсын хэмжээнд 201.6 мянга байгаагийн 127.7 (63.3%) мянга нь ажилгүй хүн, 58.8 (29.2%) мянган нь боломжит ажиллах хүч, 15.1 (7.5%) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна. Нийт хөдөлмөрийн дутуу ашиглалтын 89.0 (44.2%) мянга нь Улаанбаатар хотод, үлдсэн 112.6 (55.8%) мянга нь 21 аймагт байна.

**Хүснэгт 7.3. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, байршил, бус, хүйсээр**

Бус	Бүгд		Ажилгүй хүн		Боломжит ажиллах хүч		Цаг хугацаанаас хамаарсан хөдөлмөр эрхлэлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Улсын дүн	201 634	100.0	127736	100.0	58 800	100.0	15 098	100.0
Баруун	35 634	17.7	19 542	15.3	13 091	22.3	3 001	19.9
Хангайн	34 089	16.9	21 327	16.7	9 597	16.3	3 165	21.0
Төвийн	26 098	12.9	16 625	23.0	7 802	13.3	1 671	11.0
Зүүн	16 773	8.3	11 773	9.2	3 396	5.8	1 604	10.6
<b>УБ</b>	<b>89 040</b>	<b>44.2</b>	<b>58 469</b>	<b>45.8</b>	<b>24 914</b>	<b>42.4</b>	<b>5 657</b>	<b>37.5</b>

Эх үүсвэр:ҮСГ, Ажиллах хүчний судалгаа

Улсын хэмжээнд цалин хөлс, орлого олох зорилгоор ажил хайх эсвэл ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн ам буюу боломжит ажиллах хүч 58.8 мянга байгаагийн 24.9 (42.3%) мянга нь Улаанбаатар хотод байна.



## БҮЛЭГ 8. АЮУЛГҮЙ БАЙДАЛ

*Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн<sup>10</sup>.*

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдэлээс баттай хамгаалагдсан байх явдал юм. Нэг ч хүн хохирохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн улс орны туршлага хаана ч байхгүй бөгөөд байх ч боломжгүй. Гэхдээ л иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг тасралтгүй үр ашигтай явуулах, нэгэнт хохирсон тохиолдолд түүний хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн тогтолцоо, үйл ажиллагааны зохистой нөхцөлийг цогцоор нь бүрдүүлэх явдал аль ч улс орны хувьд нэн чухал байдаг.

<sup>10</sup> Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

### 8.1 Гамшгийн тоо

2019 онд нийслэл хотын нутаг дэвсгэрт 256 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 33.8 хувиар буурсан байна. Нийт гамшигт газар хөдлөлт 1, аадар бороо, үер 2, гахайн мялзан өвчин 3, хүний үйл ажиллагаатай холбоотой 250 осол бүртгэгдсэнээс хүний үйл ажиллагаатай холбоотой осолд химийн бодисын 1 осол, усны 16 осол, бусад төрлийн 233 осол бүртгэгджээ. Гамшгийн улмаас 65 хүн амь насаа алдаж, 361 хүнийг аварсан байна. зарцуулжээ.

### 8.2 Гал түймрийн тоо

Нийслэл хотод 2019 онд ахуйн 2824 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар өсөв. Гал түймрийн улмаас 21 хүн (үүнээс, хүүхэд 4) амь насаа алдаж, 18 хүн (үүнээс, хүүхэд 1) түлэгдэж гэмтсэн байна.

Хүснэгт 8.1 Гал түймрийн тоо, дүүргээр, 2019


Дүүрэг	2016	2017	2018	2019
БНД	41	32	30	44
БХД	8	3	6	7
БГД	411	367	412	358
БЗД	606	593	665	674
НД	95	87	84	56
СХД	540	569	587	732
СБД	285	326	291	372
ХУД	224	259	268	276
ЧД	274	266	258	305
<b>Нийслэл</b>	<b>2484</b>	<b>2502</b>	<b>2601</b>	<b>2824</b>

Эх үүсвэр: Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистик эмхэтгэл, 2019

### 8.3 Гал түймрийн шалтгаан

Гал түймрийн аюулаас 1058 хүн, 921 байшин барилга, 42.3 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 473, санамсаргүй байдлаас 2095, санаатай үйлдлээр 3, шалтгаан тогтоогдоогүй 59, бусад шалтгаанаар 194 гал түймэр гарчээ.

Зураг 8.1. Гал түймрийн шалтгаан, хувиар



Эх үүсвэр: Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистик эмхэтгэл, 2019

### 8.4 Гэмт хэргийн түвшин, төрлөөр

Нийслэлийн хэмжээнд 2019 онд 20261 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5391 (21.0%) хэргээр буурч, гэмт хэргийн илрүүлэлт 38.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 10.1 пунктээр өсөв. Гэмт хэргийн улмаас 5036 хүн гэмтэж осолдон, 437 хүн нас барсан байна.

### 8.5 Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, төрлөөр

Бүртгэгдсэн гэмт хэргийн 34.9 хувийг хулгайн, 28.2 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 20.6 хувийг залилан, 3.9 хувийг дээрмийн, 3.2 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.9 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 1.1 хувийг хүчин, 1.3 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 0.6 хувийг хүн амины, 0.1 хувийг танхайн, 4.2 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 8.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо, төрлөөр, 2019

№	Гэмт хэргийн төрөл	2017	2018	2019
1	Нийслэлийн дүн	21 947	25 652	20261
2	Хүний амь	118	110	110
3	Хүчин	194	269	214
4	Дээрэм	1 081	1 360	738
5	Хулгай	8 667	9 539	6 537
6	Залилан	2 659	4 735	3 859
7	Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	5 392	5 867	5 283
8	Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн	652	517	595
9	Бусдыг амиа хорлоход хүргэх	336	299	241
10	Ашиглах	221	386	351
11	Танхайрах	562	41	16
12	Бусад	2 019	2 529	772

Эх үүсвэр: Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистик эмхэтгэл, 2019

### 8.6 Гэмт хэргийн тоо, дүүргээр

2019 оны байдлаар нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 27.1 хувь Баянзүрх, 17.1 хувь Сонгинохайрхан, 16.2 хувь Сүхбаатар, 14.0 хувь Баянгол, 13.0 хувь Чингэлтэй, 10.1 хувь Хан-Уул дүүрэгт тус тус бүртгэгдсэн байна.

Зураг 8.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо, дүүргээр, 2019



Эх үүсвэр: Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистик эмхэтгэл, 2019

### 8.7 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо

2019 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 16347(80.7%) нь хөнгөн хэрэг, 3914 (19.3) нь хүнд хэрэг эзэлж байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 9195 болж, өмнөх оны мөн үеэс 351 (4.0%) хүнээр өссөн байна. Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 2062 (22.4%) нь согтуугаар, 1097 (11.9%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 787 (8.6%) нь хүүхэд, 1456 (15.8%) нь эмэгтэйчүүд байв.


### 8.8 Гэмт хэргийн шийдвэрлэлт

Улсын хэмжээн дунджаар 16, түүнээс дээш насны 10 000 хүн тутамд 2019 онд 148 гэмт хэрэг бүртгэгдсэн бол шүүхээр 59 эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн байна. УБ хотод 16, түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 207 болж, улсын дунжаас 59 (39.9%)-өөр их байна. УБ хотод 2019 онд 20.3 мянган гэмт хэрэг бүртгэгдсэний 7.4 (36.3%) мянган хэрэгт нь эрүүгийн хэрэг үүсгэж, шүүхээс ял оногдуулсан байна.

### 8.9 Бүртгэгдсэн гэмт хэрэг, цаг, байрлал, хувиар

Улаанбаатар хотод 2019 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 5706 (28.2%) нь шөнийн 21 цагаас өглөөний 05 цагийн хооронд, 29.5 % нь 14-18 цагийн хооронд, 28.2 % нь 06-13 цагийн хооронд, 14.1 % нь 18-21 цагийн хооронд үйлдэгдсэн бөгөөд бүртгэгдсэн гэмт хэргийн 31.5 % нь гэр, орон сууцанд үйлдэгдэж, өмнөх оноос 0.7 пунктээр, 18.6 % нь гудамж, талбайд үйлдэгдэж, 2.8 пунктээр, 12.0% нь олон нийтийн газарт үйлдэгдэж, 1.6 пунктээр, 8.8 % нь аж ахуйн нэгжид үйлдэгдэж, 1.2 пунктээр, 0.8% нь нийтийн тээвэрт үйлдэгдэж, 0.3%-аар тус тус буурч, харин төрийн байгууллагад үйлдэгдсэн хэрэг 3.1% болж, өмнөх оноос 0.7 пунктээр, авто зам дээр үйлдэгдсэн хэрэг 4.1 пункт болж, 0.7 пунктээр, бусад 20.3 % болж, 5.0 пунктээр өссөн байна.

Зураг 8.3. Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, хувиар, 2018-2019 он



Эх үүсвэр: УСХ, Гэмт хэргийн статистик-2019

### 8.10 Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн тоо

Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн 59.4 хувь, хүнийг санаатай алах гэмт хэргийн 105 (55.8%) нь УБ хотод гарсан. Хүнийг санаатай алах гэмт хэрэг 25 (23.8%) Баянзүрх, 20 (19.0%) нь Чингэлтэй, 17 (16.2%) нь Сонгинохайрхан, 17 (16.2%) нь Хан-Уул, 15 (14.3%) нь Баянгол, 9 (8.6%) Сүхбаатар дүүрэгт, хүний амьд явах эрхийн эсрэг 378 гэмт хэргийн 112 нь Баянзүрх, 68 нь Сонгинохайрхан, 60 нь Баянгол, 37 нь Чингэлтэй дүүргүүдэд тус тус гарчээ.

*Хүснэгт 8.3. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, нийслэл, дүүргээр, 2019 он*


Дүүрэг	Хүний амьд явахын эрхийн эсрэг		Хүнийг санаатай алах		Хүнийг амиа хорлоход хүргэх		Хүний амь насыг болгоомжгүй хохироох	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
<b>УБ</b>	<b>433</b>	<b>378</b>	<b>110</b>	<b>105</b>	<b>299</b>	<b>241</b>	<b>19</b>	<b>25</b>
БЗД	104	112	22	25	78	80	2	6
СХД	103	68	30	17	71	45	1	6
БГД	64	69	14	15	46	42	4	3
ХУД	46	50	6	17	36	27	4	5
СБД	57	34	14	9	41	24	4	5
ЧД	38	37	19	20	16	16	1	1
БНД	6	4	1	2	3	0	2	2
НД	15	13	4	0	8	7	3	1

Эх үүсвэр: УСХ, Гэмт хэргийн статистик-2019

### 8.11 Хулгайлах гэмт хэргийн тоо

2019 онд бүртгэгдсэн нийт хулгайлах гэмт хэргийн 6537 (72.9%) нь УБ хотод бүртгэгдсэний 1947 (29.8%) нь Баянзүрх, 1256 (19.2%) нь Сонгинохайрхан, 999 (15.3%) нь Сүхбаатар, 888 (13.6%) нь Чингэлтэй, 763 (11.7%) нь Баянгол дүүрэгт тус тус гарчээ.

*Зураг 8.4. Хулгайлах гэмт хэрэг, дүүргээр, 2018-2019 он*



Эх үүсвэр: УСХ, Гэмт хэргийн статистик-2019



### 8.12 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тоо

Улсын хэмжээгээр бүртгэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 1276 гэмт хэргийн 595 (46.6%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 4.6 пунктээр өссөн байна.

Авто зам дээр гарсан нийт хэргийн 614 (46.9%) нь Улаанбаатар хотод гарсан нь өмнөх оноос 0.8 пунктээр өссөн байна. Зам тээврийн ослын улмаас нас барсан 49 хүүхдийн 26 (53.1%) нь 0-7 насны хүүхэд, 19 (38.8%) нь 8-13 насны хүүхэд, 4 (8.2%) нь 14-17 насны хүүхэд байна. Зам тээврийн ослын улмаас нас барсан 49 хүүхдийн 11 (22.4%) нь УБ хотынх байна.

### 8.13 Хүн худалдаалах гэмт хэргийн тоо

Улсын хэмжээгээр 2019 онд хүн худалдаалах гэмт хэрэг 14 бүртгэгдсэн нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийн 12.2%-ийг эзэлж байна. Хүн худалдаалах 14 гэмт хэргийн 12 (85.7%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. 2019 онд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч 9 хүний 5 (55.6%) нь 14-17 насных, 3 (33.3%) нь 18-24 насных, 1 (11.1%) нь 40, түүнээс дээш насны хүн байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг насны ангиллаар авч үзвэл жил тутам ихэвчлэн 14-24 насныхан хохирсоор байна.

Хүчиндэх гэмт хэрэг 1995 онд улсын хэмжээгээр бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 1.8%, 2000 онд 1.5%, 2005 онд 1.8 %, 2010 онд 1.7%, 2015 онд 1.0%, 2018 онд 1.4%-ийг эзэлж байсан бол 2019 онд 1.5%-ийг эзэлж өмнөх оноос 0.1 пунктээр өссөн байна. Бүртгэгдсэн 481 хүчиндэх гэмт хэргийн 214 (44.5%) нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.



## БҮЛЭГ 9. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

*Монгол Улс 2016 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан, 2017 оноос эхлэн мөрдөж байгаагаас гадна Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт энэ чиглэлийн асуудлыг тусган өгч, хэрэгжүүлж байгаа. Түүнчлэн хүчирхийлэлд өртсөн иргэдэд тусламж, зөвлөгөө өгөх, хамгаалах байраар хангах зэрэг үйлчилгээ үзүүлж байна.*

*Гэр бүлийн хүчирхийлэл гэж эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү, гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ<sup>11</sup>.*

---

<sup>11</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

## 9.1 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоо

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)—ээр зүйлчлэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2019 онд 207 бүртгэгдсэн нь өмнөх оноос 3 (1.4%)-аар буурсан байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн 207 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн **130** (62.8%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 25 (23.8%)-аар буурсан байна

## 9.2 Хамтарсан багийн болон гишүүдийн тоо

Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална. Хамтарсан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.<sup>12</sup> Үүнд:

- i. гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг төрийн бус байгууллагатай хамтран явуулах;
- ii. хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;
- iii. нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- iv. хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;
- v. хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;
- vi. хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаархи статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх.

Нийслэлд 2020 оны байдлаар 170 Хамтарсан багийн **1146** гишүүд ажиллаж байна.

Зураг 9.1. Хамтарсан баг, гишүүдийн тоо, 2020




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

<sup>12</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

### 9.3 Хамтарсан багийн шийдвэрлэсэн кейсийн тоо

2020 онд нийслэлийн хэмжээнд Хамтарсан баг **1675** кейс дээр ажиллаж шийдвэрлэсэн бөгөөд 1252 кейс дээр үргэлжлүүлэн ажиллаж байна.

Зураг 9.2. Хамтарсан багийн шийдвэрлэсэн кейсийн тоо




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.4 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод явуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо

Нийслэлийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн талаар 751 удаагийн сургалт явуулж, **17118** хүн хамрагдсан байна.

Зураг 9.3. Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.5 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод явуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо

2020 онд нийслэлийн хэмжээнд **4852** эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэн, хүчирхийллийг таслан зогсоосон бөгөөд Хан-Уул дүүрэгт хамгийн өндөр буюу 3478 өрхийг илрүүлсэн байна.

**Зураг 9.4.** Эрсдэлтэй гэр бүлийг илрүүлсэн, таслан зогсоосон гэр бүлийн тоо




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.6 Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн тоо

“Түр хамгаалах байр” гэж хохирогчийг, тодорхой хугацаагаар байрлуулан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан үйлчилгээг үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг хэлнэ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 06 дугаар сарын 13 –ны өдрийн А/116 дугаар тушаалаар баталсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг хэрэгжүүлж ажиллана. *Нэг цэгийн үйлчилгээ* гэж хохирогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж үйлчилгээг нэг дор үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ<sup>13</sup>. Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 14 –ний өдрийн А/38 дугаар тушаалаар батлагдсан “нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам”-ыг баримталж ажиллана.

2020 онд Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээнд **887** хүүхэд, **77** насанд хүрэгчид хамрагдсан байна.

**Зураг 9.5.** Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн тоо, 2020




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

<sup>13</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

### 9.7 Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн тоо

2020 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн **575** хүүхэд, **532** насанд хүрэгчдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Зураг 9.6. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн тоо, 2020




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.8 Сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн тоо

2020 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн **736** хүүхэд, **1682** насанд хүрэгчдэд сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан байна.

Зураг 9.7. Сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн тоо




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.9 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн тоо

2020 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн **2826** хүүхэд, **4782** насанд хүрэгчид, **4885** өрхөд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн байна.

**Зураг 9.8. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан өрх, хүүхэд, насанд хүрэгчдийн тоо**




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.10 Эрхзүйн туслалцаа үзүүлсэн хүүхэд, насанд хүрэгчдийн тоо

2020 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн **672** хүүхэд, **1085** насанд хүрэгчдэд эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлсэн байна.

**Зураг 9.9. Эрхзүйн туслалцаа үзүүлсэн хүүхэд, насанд хүрэгчдийн тоо**




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.11 Дэмжин, холбон зуучлах үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн тоо

2020 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн **1156** хүүхэд, **767** насанд хүрэгчдэд дэмжин, холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн байна.

**Зураг 9.10. Дэмжин, холбон зуучлах үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, насанд хүрэгчдийн тоо**



Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.12 Хөдөлмөр эрхлэлтэд зуучилсан иргэдийн тоо

2020 онд **535** иргэнд хөдөлмөр зуучлалын үйлчилгээ үзүүлсэн бөгөөд Чингэлтэй дүүрэг хамгийн олон 257 иргэнийг хөдөлмөр эрхлэлтэд зуучилсан байна.

Зураг 9.11. Хөдөлмөр эрхлэлтэнд зуучилсан иргэдийн тоо




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.13. Хамтарсан багийн шийдвэрлэсэн кейсийн тоо

2020 онд нийслэлийн хэмжээнд хороодын Хамтарсан баг нийт **2035** кейсийг шийдвэрлэж ажилласан бөгөөд 1470 эмэгтэй, 565 эрэгтэй хүүхэд хамрагджээ.

Зураг 9.12. Шийдвэрлэсэн кейсийн тоо



Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 4.12 Хүүхдийн хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо

2020 онд нийслэлийн хэмжээнд Хүүхдийн хууль зүйн хорооны үйлчилгээнд **354** хүүхэд хамрагдсан байна.



**Зураг 9.13.** Хүүхдийн хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.13 Гэр бүлд нь эргэн нэгтгэсэн хүүхдийн тоо

2020 онд нийслэлийн хэмжээнд нийт **784** хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэсэн байна.

**Зураг 9.14.** Гэр бүлд нь эргэн нэгтгэсэн хүүхдийн тоо




Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

### 9.14 Төрөл садны хамгаалалтад өгсөн хүүхэд, насанд хүрэгчдийн тоо

2020 онд нийслэлд хүчирхийллийн улмаас **658** хүүхэд, **89** насанд хүрэгчдийг төрөл садны хамгаалалтад өгсөн байна.

**Зураг 9.15.** Төрөл садны хамгаалалтанд өгсөн хүүхэд, насанд хүрэгчдийн тоо



Эх үүсвэр: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

## НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛЭЭС

### **Хоёр. Хүний хөгжил**

*Зорилго 2. Хүн амыг эрүүл, сайхан амьдрах нөхцөлөөр ханган, чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, өндөр мэдлэг чадвартай, ёс суртахуунтай хариуцлагатай, тогтмол орлоготой, бүтээлч нийслэлийн иргэнийг төлөвшүүлнэ.* Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

#### **Боловсрол**

- Зорилт 2.1. Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг мэргэжлийн багшаар бүрэн хангана.
- Зорилт 2.2. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдах, бага боловсрол эзэмшихэд бэлтгэх нөхцөлөөр хангана.
- Зорилт 2.3. Хүүхэд бүрийг төлбөргүй, тэгш, чанартай бага болон суурь боловсрол эзэмших нөхцөлөөр хангана.
- Зорилт 2.4. Боловсролын байгууллагуудыг хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй болгон хөгжүүлж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчин нөхцөлөөр хангана.

#### **Эрүүл мэнд**

- Зорилт 2.5. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх замаар халдварт бус өвчнөөс үүдэлтэй нас баралтын хувийг бууруулна.
- Зорилт 2.6. Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан, өвчлөлийг бууруулна.
- Зорилт 2.7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бий болгоно
- Зорилт 2.8. Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.
- Зорилт 2.9. Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрд хүргэнэ.
- Зорилт 2.10. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.
- Зорилт 2.11. Хотын хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, тэр дундаа нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай хүргэж, аюулгүй, үр дүнтэй, нэн хэрэгцээтэй эм, вакцинаар ханган, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.

#### **Гэр бүл**

- Зорилт 2.12. Гэр бүлийн боловсрол, хөгжил, төлөвлөлтийг хийж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангана.
- Зорилт 2.13. Эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах болон хууль бус наймаа, бэлгийн мөлжлөг зэрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгана
- Зорилт 2.14. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зогсооно

#### **Угийн бичиг**

Зорилт 2.16. Угийн бичиг хөтлөлтийг дэлгэрүүлэн таниулна.

----- оОо -----